



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2021 Э-сонин

06-Р САР

95-р дугаар






Зах зээлийн тойм


/2021.06.30-ны өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр	20
2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/	26,686,194,114.79
Хувьцаа /хоёрдогч/	7,144,916,968
Багцын арилжаа	182,286,499,541.30
Хөрөнгө оруулалтын сан /хоёрдогч/	344,341,583.79
Компанийн бонд /анхдагч/	8,000,000,000
Компанийн бонд /хоёрдогч/	11,196,580,563
ХБҮЦ /хоёрдогч/	355,000
3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг	24,078,473
Хувьцаа /хоёрдогч/	22,457,222
Багцын арилжаа	94,732,818
Хөрөнгө орцлалтын сан /хоёрдогч/	1,430,536
Компанийн бонд /анхдагч/	80,000
Компанийн бонд /хоёрдогч/	110,714
ХБҮЦ /хоёрдогч/	1
4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо	14,163


TOP-20 индекс




MSE B индекс



Зах зээлийн үнэлгээ



MSE A индекс



БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС

1. Нийт үнэт цаас	185
100% төрийн өмчит	17
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	158
I ангилал	18
II ангилал	42
III ангилал	125
Компанийн бонд	2
Хөрөнгө оруулалтын сан	1
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	53
Үүнээс: Брокер, Дилер	53
Андеррайтер	16
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



АРИЛЖААНД ИДЭВХТЭЙ ОРОЛЦСОН ГИШҮҮН ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУД

/2021.06.30-ны байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (төг)
		Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	Тоо ширхэг	Үнийн дүн (төг)	
1	БИ ДИ СЕК ХК	1,133,092	378,023,501	9,932,593	11,639,746,927.10	12,017,770,427.86
2	БУЛГАН БРОКЕР ХХК	110,000	11,000,000,000	24,897	12,684,858.00	11,012,684,858.00
3	ИНВЕСКОР КАПИТАЛ ҮЦК	30,935	2,415,475,685	81,852	8,002,519,570.00	10,417,995,255.00
4	АРД СЕКЮРИТИЗ ХХК	4,731,081	4,878,183,631	4,079,734	4,581,346,496.76	9,459,530,127.38
5	ГОЛОМТ КАПИТАЛ ХХК	2,131,274	4,291,897,876	2,881,665	714,729,468.52	5,006,627,344.02
6	БУМБАТ-АЛТАЙ ХХК	962,747	426,477,405	2,737,732	580,343,159.05	1,006,820,563.89
7	ЗЭТ ЖИ БИ ХХК	9,134	913,400,000	-	-	913,400,000.00
8	ТИ ДИ БИ КАПИТАЛ ХХК	1,392,226	610,152,141	884,824	207,323,148.89	817,475,290.08
9	ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ХХК	8,900,566	513,074,954	1,021,268	111,014,941.99	624,089,895.56
10	АПЕКС КАПИТАЛ ҮЦК	1,519,107	282,869,430	795,063	268,716,244.05	551,585,673.72
11	СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ ХХК	662,766	231,239,800	747,253	181,404,570.16	412,644,370.46
12	ЭМ АЙ БИ ЖИ ХХК	2,100	210,000,000	-	-	210,000,000.00
13	РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК	1,781,710	176,048,075	103,301	29,221,095.00	205,269,169.98
14	НЭЙШНЛ СЕКЮРИТИЗ ХХК	136,641	102,071,701	90,119	90,129,722.31	192,201,422.82
15	НОВЕЛ ИНВЕСТМЕНТ ХХК	105,699	63,763,865	124,421	40,074,072.33	103,837,936.96
16	ГАУЛИ ХХК	99,655	20,568,242	33,433	47,837,889.67	68,406,131.47
17	МИРЭ ЭССЭТ СЕКЮРИТИС МОНГОЛ ХХК	40,633	46,871,571	126,310	15,707,716.19	62,579,287.25
18	АРГАЙ БЕСТ ХХК	29,651	48,555,368	34,044	4,768,090.88	53,323,458.83
19	МАСДАК ХХК	-	-	13,184	35,499,327.00	35,499,327.00
20	ГҮҮДСЕК ХХК	50,904	6,623,459	96,133	21,892,891.20	28,516,350.22

ИДЭВХТЭЙ АРИЛЖИГДСАН ХУВЬЦАА

/2021.06.30-ны байдлаар/

№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн (төг)	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт /%/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	272,984	2,622,194,770.00	10,500.00	8,400.00	-14.14
2	BUN	БУЛГАН УНДРАГА	11,606	1,539,423,900.00	230,000.00	100,000.00	92.60
3	ADB	АРД КРЕДИТ ББСБ ХК	2,054,327	476,632,159.76	267.00	195.00	-7.13
4	APU	АПУ	578,150	420,795,262.41	810.00	710.00	11.25
5	TUM	ТҮМЭН ШУВУУТ	1,926,602	406,176,256.18	220.00	210.00	1.01
6	HBO	ХАЙ БИ ОЙЛ	8,288,798	361,648,190.20	57.00	43.60	-5.00
7	XOC	ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН	1,430,536	344,341,583.79	284.50	195.00	-3.16
8	AIC	АРД ДААТГАЛ ХК	196,876	248,609,910.00	1,492.00	1,100.00	11.17
9	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	2,097,969	147,971,700.72	73.50	68.01	1.40
10	LEND	ЛЭНДМН ББСБ ХК	2,478,949	113,806,116.04	47.50	44.32	2.02
11	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИЙН ХК	123,301	107,924,788.15	920.00	869.00	-0.78
12	GOV	ГОВЬ	413,203	98,473,797.54	255.00	231.00	6.21
13	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	77,919	96,046,715.00	1,330.00	1,070.00	-7.99
14	ITLS	АЙТҮҮЛС	769,972	86,999,868.87	129.00	95.00	20.86
15	TTL	ТАВАН ТОЛГОЙ	8,406	58,251,890.00	6,990.00	6,805.00	2.65
16	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	24,925	50,067,781.00	2,200.00	1,870.00	2.34
17	BODI	БОДЬ ДААТГАЛ	400,742	48,575,013.63	125.50	115.00	1.26
18	MFC	МОНОС ХҮНС	550,732	36,195,522.58	68.50	62.51	-2.85
19	BAN	БАГАНУУР	29,167	33,292,553.00	1,300.00	950.00	0.00
20	SUU	СҮҮ	133,444	28,836,485.83	249.00	207.00	15.45



ХАНШИЙН ӨСӨЛТТЭЙ ХУВЬЦАА

/2021.06.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан / Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %/
			2021-06-01	2021-06-30		
1	БУЛГАН УНДРАГА	11,606	87,280.00	168,100.00	80,820.00	92.60
2	ТЕХНИК ИМПОРТ	5	9,250.00	12,220.00	2,970.00	32.11
3	ДАРХАН ХӨВӨН	2	7,900.00	10,100.00	2,200.00	27.85
4	МОНГОЛ САВХИ	146	595.00	728.99	133.99	22.52
5	АЙТҮҮЛС	769,972	98.68	119.26	20.58	20.86
6	ЭРДЭНЭС СОЛЮШИНС	3,603	86.00	103.00	17.00	19.77
7	УЛААНСАН	489	931.00	1,100.00	169.00	18.15
8	ТҮШИГ УУЛ	9,660	895.00	1,050.00	155.00	17.32
9	СҮҮ	133,444	207.00	238.98	31.98	15.45
10	ШИВЭЭ ОВОО	1,934	1,528.00	1,740.00	212.00	13.87
11	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	2,657	602.18	682.42	80.24	13.32
12	МИК ХОЛДИНГ	63	12,800.00	14,490.00	1,690.00	13.20
13	НАКО ТҮЛШ	100	24.00	27.00	3.00	12.50
14	УВС ЧАЦАРГАНА	3	386.00	430.00	44.00	11.40
15	АПУ	578,150	714.00	794.33	80.33	11.25
16	АРД ДААТГАЛ	196,876	1,307.00	1,453.00	146.00	11.17
17	МОНГОЛ БАЗАЛТ	79,373	161.00	172.00	11.00	6.83
18	ГОВЬ	413,203	235.35	249.96	14.61	6.21
19	АДУУН ЧУЛУУН	1,248	850.00	900.00	50.00	5.88
20	МОНГОЛ НЭХМЭЛ	160	1,800.00	1,900.00	100.00	5.56

ХАНШИЙН БУУРАЛТТАЙ ХУВЬЦАА

/2021.06.30-ны байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (төг)		Ханшийн өөрчлөлт (төг)	Өөрчлөлт %
			2021-06-01	2021-06-30		
1	ГАН ХИЙЦ	87	13,350.00	7,400.00	-5,950.00	-44.57
2	МОНГОЛ АЛТ	700	18,000.00	12,650.00	-5,350.00	-29.72
3	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	39,019	149.99	117.00	-32.99	-21.99
4	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	420	510.00	400.00	-110.00	-21.57
5	ЖЕНКО ТУР БҮРО	25,931	69.20	58.36	-10.84	-15.66
6	СОНСГОЛОН БАРМАТ	10	1,810.00	1,550.00	-260.00	-14.36
7	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	272,984	10,930.00	9,385.00	-1,545.00	-14.14
8	БЭРХ УУЛ	10	2,106.00	1,850.00	-256.00	-12.16
9	ХАР ТАРВАГАТАЙ	110	5,000.00	4,400.00	-600.00	-12.00
10	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	112	170.00	150.00	-20.00	-11.76
11	ШАРЫН ГОЛ	4	850.00	755.00	-95.00	-11.18
12	ХӨХ ГАН	10,679	80.00	72.00	-8.00	-10.00
13	ХӨДӨӨГИЙН ТЭЭВЭР	2	5,000.00	4,500.00	-500.00	-10.00
14	МАТЕРИАЛИМПЕКС	302	7,415.00	6,730.00	-685.00	-9.24
15	МОНГОЛ ШУУДАН ХК	77,919	1,301.00	1,197.00	-104.00	-7.99



"ИНВЕСКОР БОНД"-ЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН АРИЛЖАА АМЖИЛТТАЙ ЯВАГДЛАА.



Монголын Хөрөнгийн Биржийн TOP-20 индекст багтдаг "Инвескор ББСБ" ХК нь хувийн хэвшлийн түүхэн дэх хамгийн өндөр дүн бүхий нээлттэй өрийн хэрэгслийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн Транч 1-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлэх цан цохих ёслол 2021 оны 6-р сарын 14-ний өдөр боллоо.

Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны Дэд дарга Т.Цэрэнбадрал, "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Алтай, "Инвескор ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баясгалан, "Инвескор Капитал ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Уянгахишиг нар оролцож Монголын Хөрөнгийн Биржийн 6491 дэх үнэт цаасны арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.



"Инвескор Бонд" хөтөлбөрийн хүрээнд нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 200,000 хүртэлх ширхэг үнэт цаасыг зах зээл дээр гаргах замаар 20 тэрбум хүртэлх төгрөгийг татан төвлөрүүлэх юм. Тус бонд нь 2 жилийн хугацаатай, жилийн 12-14 хувийн өгөөжтэй бол хүү төлөх давтамж хагас жилд нэг удаа, хүүгийн орлогын албан татвар 5% байна.

ҮЙЛ ЯВДАЛ

Харин эхний транчийн хувьд 8 тэрбум төгрөг хүртэлх дүнтэй өрийн хэрэгслийг жилийн 13% хүүтэйгээр худалдан борлуулах ба уг транчийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021 оны 6-р сарын 14-ны өдрөөс 6-р сарын 16-ны өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд МХБ-ийн гишүүн бүх үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авч тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд стратегийн 11 хөрөнгө оруулагчаас 3,723,700,000 төгрөгийн үнийн дүн бүхий 11 захиалга, олон нийт буюу 61 хөрөнгө оруулагчаас 10,315,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий 61 захиалга, нийт 14,038,700,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 72 захиалга ирүүлсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 75.5%-аар давсан дүн боллоо.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 10 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100 хувь биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгад үнэт цаасыг 39.4 хувиар хувь тэнцүүлэн хуваарилав.

BANK IPO | ТА АЛЬ БАНКНЫ ХУВЬЦАА АВАХ ВЭ? НЭЭЛТТЭЙ ВЕБИНАР ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА.

Банк нь хөрөнгийн зах дээлд IPO хийхтэй холбогдуулан иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор 6 сарын 24-ний өдөр BANK IPO нээлттэй вебинарыг зохион байгуулав. Уг вебинарт санхүүгийн зохицуулагч байгууллага, банк, хөрөнгийн захын төлөөллүүд, мэргэжлийн байгууллагууд болон олон нийт оролцов.

Уг хамтарсан вебинарын шууд дамжуулалт 1,500 хүрсэн бол социал хандалт 1,100, давтан үзэлт 56,700 болсон амжилттай байлаа.



BANK IPO | ТА АЛЬ БАНКНЫ ХУВЬЦАА АВАХ ВЭ?

ВЕБИНАРЫН ХӨТӨЛБӨР

13:45-14:00	Бүртгэл
14:00-14:05	Нээлт
14:05-14:15	Илтгэл I: Банкны IPO Хууль эрх зүйн орчин Монголбанк
14:15-14:45	Хэлэлцүүлэг I: Банкны IPO Явц Монголбанк Санхүүгийн зохицуулах хороо Голомт банк ХасБанк
14:45-14:55	Илтгэл II: Банкны IPO ба Хөрөнгө оруулагчид Мандал ассет менежмент
14:55-15:25	Хэлэлцүүлэг II: Хөрөнгийн зах ба Банкны IPO Монголын хөрөнгийн бирж Мандал санхүүгийн нэгдэл Монголын үнэт цаас арилжаа эрхлэгчдийн холбоо Голомт банк
15:25-15:30	Хаалт

Нээлттэй вебинар

6 САРЫН 24-НД 14:00 ЦАГААС



"ЛЭНД БОНД"-ЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН НЭЭЛТИЙН ЁСЛОЛ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 258 тоот тогтоолоор "ЛэндМН ББСБ" ХК-ийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй, нийт 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 50,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэж, нийтэд санал болгон арилжаалахыг зөвшөөрсөн байна.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй "Лэнд МН ББСБ" ХК-ийн гаргаж буй "Лэнд Бонд"-ын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа 6 дугаар сарын 25-ны өдөр болж өнгөрлөө. Энэхүү арга хэмжээнд Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны газрын дарга С.Цэрэндаш, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хяналт зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан, "Лэнд МН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Одмаа, "Лэнд МН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатар, "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6,500 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.

"Лэнд МН ББСБ" ХК нь МХБ-ийн үнэт цаасны бүртгэлийн 1-р ангилалд бүртгэлтэй бөгөөд 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, хоёр жилийн хугацаатай, жилийн 14 хувийн хүүтэй, нийт 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 50,000 ширхэг өрийн хэрэгслийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгон гаргалаа.

"Лэнд Бонд"-ын үндсэн андеррайтераар "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК, туслах андеррайтераар "Райнос инвестмент ҮЦК" ХХК ажилласан бөгөөд үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалгыг 2021 оны 6 дугаар сарын 25-29-ний өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд, 6 дугаар сарын 30-ны өдөр 10:00-15:00 цагийн хооронд авч нийт 5.0 тэрбум төгрөгийн

санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ.

Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд нийт 504 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийт 75,835 ширхэг буюу 7,583,500,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 505 худалдан авах захиалга ирүүлсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 51.6 хувиар давсан дүн юм.





"ГОВЬ" ХК 1500 АЖИЛТНАА ХУВЬЦААГААР УРАМШУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн I ангилалд бүртгэлтэй "Говь" ХК нь 1500 ажилтнаа хувьцаагаар урамшуулах хөтөлбөрийг эхлүүлж байгаатай холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр зохион байгуулагдлаа. Энэхүү үйл ажиллагаанд "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хяналт зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан, "Говь" ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан, УИХ гишүүн Ж.Батжаргал, Төв аймгийн засаг дарга Д.Мөнхбаатар, "Говь" ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа, "Таван богд капитал" ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мөнх-Эрдэнэ нар оролцож, Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6,502 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.



Нээлтийн үйл ажиллагааны үеэр "Говь" ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан хэлэхдээ 2007 онд хувьчлагдсанаас хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 148 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, борлуулалтын орлогыг 11 дахин, хувьцааны ханшийг 13 дахин өсгөсөн байна. Өнөөдөр цар тахалтай холбоотойгоор компани, хувь хүн бүрийн өмнө багагүй бэрхшээл тулгамдаж байгаа ч "Говь" ХК-ийнхэн бид энэ бүхнийг үл харгалзан дэлхийн зах зээлд үйл ажиллагаагаа улам тэлж байгаагаас гадна орон нутгийн хөгжилд өөрийн оролцоог нэмэгдүүлэх томоохон зорилгын дор Төв аймагт үйлдвэр цогцлоох төсөл хэрэгжүүлж байгаа тухай онцлон дурдсан юм.

Хөтөлбөрийн хүрээнд нийт 800,900 ширхэг хувьцааг ажилтнуудын нэр дээрх дансанд худалдан авч байршуулах бөгөөд тусгайлан баталсан журам болон ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээний дагуу



захиран зарцуулах үйл ажиллагааг зохицуулсан байна.

"Говь" ХК нь 1981 онд байгуулагдсан, ямааны ноосыг технологийн өндөр түвшинд боловсруулж дэлхийд танигдсан ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ тэргүүлэгч брэнд төдийгүй Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индексийн багцад багтдаг, үйл ажиллагаа, компанийн засаглалаараа тэргүүлэгч компаниудын нэг юм.



"ЛЭНД БОНД"-ЫН ЭРГЭН ТӨЛӨЛТ ХИЙГДЛЭЭ

МХБ-ийн 1-р ангилалд бүртгэлтэй "ЛэндМН ББСБ" ХК нь 2020 оны 6 дугаар сарын 18-ний өдөр "Лэнд Бонд"-ыг МХБ-ээр дамжуулан арилжаалж олон нийтээс 5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн билээ.

Тус өрийн хэрэгслийг "ЛэндМН ББСБ" ХК нь өөрийн хувьцаагаар баталгаажуулан гаргасан бөгөөд жилийн 17 хувийн хүүтэй буюу банкны хадгаламжаас харьцангуй өндөр өгөөжтэй байсан нь хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлснээс гадна олон ААН-үүдэд бага зардлаар өөрсдийн бизнесийн санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой болохыг харуулж чадсан юм. Мөн "Лэнд Бонд" нь хоёрдогч зах зээл дээр идэвхтэй арилжаалагдаж, өнгөрсөн нэг жилийн хугацаанд нийт 1.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.



"МАНДАЛ ИРЭЭДҮЙН ӨСӨЛТ" САНГИЙН НЭГЖ ЭРХИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН НЭЭЛТИЙН ЁСЛОЛ БОЛЛОО



Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн "Мандал ассет менежмент УЦК" ХХК-ийн үүсгэн байгуулсан "Мандал Ирээдүйн Өсөлт" хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг эхлүүлсэнтэй холбогдуулан цан цохих ёслолын үйл ажиллагаа өнөөдөр боллоо. Ёслолын арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан, "Мандал санхүүгийн нэгдэл" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ө.Ганзориг, "Мандал ассет менежмент УЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Ганзориг болон бусад төлөөлөгчид оролцож Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны 6,503 дахь арилжааг эхлүүлэх хүндэтгэлийн цанг цохилоо.



"Мандал Ирээдүйн Өсөлт" сан нь 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, арван жилийн хугацаатай, нийт 47.5 тэрбум төгрөгийн нэгж эрхийг нийтэд санал болгон арилжаалах бөгөөд нэгж эрх гаргагч "Мандал ассет менежмент УЦК" ХХК-ийн андеррайтераар "Апекс капитал УЦК" ХХК ажиллаж байна.

Нэгж эрхийн анхдагч зах зээлийн захиалгыг 2021

ҮЙЛ ЯВДАЛ

оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс 8 дугаар сарын 10-ны өдрүүдэд 10:00-16:00 цагийн хооронд МХБ-ийн гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авна.

Тус сан нь Монголын хөрөнгийн биржид нэгж эрхээ бүртгүүлсэн хоёр дахь хамтын хөрөнгө оруулалтын сан бөгөөд олон нийтээс төвлөрүүлсэн хөрөнгийг нээлттэй зах зээлд арилжигдах хувьцаа, өрийн хэрэгсэл болон бусад төрлийн санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулахаар нэгж эрхийн танилцуулганд тусгасан байна.



ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЕЙШН ХАР МОРЬ ТАЛБАЙН II-Р УЛИРЛЫН ХАЙГУУЛЫН ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛСАН БАЙНА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Хар Морь талбайд хийсэн өрөмдлөгийн хайгуулын хөтөлбөрийн II улирлын үр дүнг танилцуулсан байна.

Хар Морь нь газрын дөт гүнд илрүүлсэн алтны шинэ нээлт бөгөөд Компанийн тэргүүлэх төсөл болох Баян Хөндий төслөөс хойд зүгт 3.5 км зайд оршдог. 2021 оны 2-р улиралд нийт 3,757 метрийн 37 цооног өрөмдсөнөөс 2,610 метрийн 27 цооногийн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг энэ мэдээгээр танилцуулж байна. Мөн Хар Морь алтны нээлтийн талбайд 3,000 метрийн өргөтгөсөн өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлснийг мэдэгдсэн байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747-2129



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN